

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА УДИРДЛАГА

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Б.Одбаатар.

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Энэхүү нийтлэлд аюулгүй байдлын тухай ойлголт, түүний мөн чанар, хамрах хүрээ, ач холбогдлын талаар авч үзэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал.

Abstract: This article aims to discuss the concept of security, its nature, scope and importance.

Keywords: Security, organizational security, internal security, personal security.

Оршил

Аюулгүй байдал нь нэн эртний ойлголт бөгөөд хүн төрөлхтөн үүсэн хөгжсөн цагаасаа өөрийн аюулгүй байдалд санаа тавьсаар ирсэн. Дэлхий ертөнцөөс эхлээд бидний хүрээлэн байгаа орчин, улс гүрэн, байгууллага, хувь хүний оршин тогтнох эсэхийг шийдвэрлэх гол хүчин зүйл бол “аюулгүй байдал” тул түүнийг хэрхэн бий болгож хангаж байгаагаас улс гүрний тусгаар байдал, иргэдийн амьдралын баталгаа хамаарч байдаг. Аюулгүй байдлын тухай уламжлалт ойлголт нь бусад улс гүрнээс үзүүлэх аюул заналхийлэл, түүнд тулгуурласан түгшүүр байдаг бол орчин цагт материаллаг аюулгүй байдлыг нийгмийн аюулгүй байдлын сүлжээ болон глобалчлалтай холбон тайлбарлах болсон. Ийм ч учраас

аюулгүй байдал нь түүхийн цаг хугацааны явцад өргөжин тэлсээр олон шинжлэх ухаан, онолын мэдлэгийн огтлолцол дээр үүсч одоо “аюулгүй байдал судлал” бие даасан шинжлэх ухааны түвшинд хүрээд байна.

Эрх зүйн толь бичигт аюулгүй байдлыг “Тухайн улсад улс төр, эдийн засаг, нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулийг чанд сахин биелүүлэх, эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төр, эдийн засаг, нийгэмшил, цэрэг, экологи, мэдээллийн болон бусад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал¹” гэж тодорхойлжээ.

¹ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. – Уб., 2007. 54 дэх тал.

Энэ бүхнээс товч дүгнэхэд “Аюулгүй байдал нь аливаа гадна, дотны сөрөг нөлөөллийн хүчин зүйлээс найдвартай, баталгаатай хамгаалагдаж, амар тайван оршин байх нөхцлийг цогц байдлаар хангасан байх ойлголт” гэж үзэж болох юм.

Түүхэн эх сурвалж, бүтээлд тусгагдсанаар “аюулгүй байдал” гэдэг ухагдахуун бүр XII зуун (1190 он)-ы үеэс хүний ойлголт, ухамсрын түвшинд, юуны урьд хүний оюун санааны амгалан тайван байдал, аливаа аюул заналаас ангид хамгаалагдсан байх тухай ойлголтод хамаардаг байсан байна.

Баруун европ дахинд XVII зууныг хүртэл ухагдахууны түвшинд төдийлэн яригдаж нэвтрээгүй бөгөөд харин XVII-XVIII зууны хооронд “дэлхийн чинээлэг аж амьдрал, түүний аюулгүй байдал” гэсэн ойлголтоор зонхилон хэрэглэгдэж байжээ.

Социалист тогтолцооны үед аюулгүй байдал гэдгийг зөвхөн цэрэг, арми, батлан хамгаалах хүчин чадалтай холбон ойлгож ирсэн ба түүхийн цаг хугацаанд 1990 оны ардчилсан хувьсгалын үрээр нийгмийн нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжин урьд мэдэхгүй байсан нийгмийн цоо шинэ харилцаанууд үүсч түүгээр ч зогсохгүй аюулгүй байдлын тухай ойлголт өргөн хүрээг хамрах болсон.

Орчин үед “бусад улс орны дотоод, гадаад аюул занал бүхнээс өөрийн орны хүн ам, хувь хүний эрх

ашиг, улс нийгмийнхээ бүрэлдэхүүн хэсэг хийгээд улс орны нийтлэг ашиг сонирхол бүхэлдээ ямар нэгэн аюул, заналгүй хамгаалагдсан бодит нөхцөл байдлыг аюулгүй байдал гэж ойлгох ёстой” гэж үзэж байна.

Аюулгүй байдал нэг талаасаа улс, нийгэм, иргэний аюулгүй байдлыг найдвартай хангах үүднээс хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд нийцсэн бодлого, хөтөлбөрийн цогц ойлголт бөгөөд аюулгүй байдлыг арилгах, саармагжуулах, ямар нэгэн өөр хөнөөлтэй үйл явц, нөхцөл байдлын улмаас үүдэлтэй хүн ам, нийгмийн эрэлт, хэрэглээ хоёрын зөрчлийг арилган саармагжуулах, цаашид аюул, хөнөөлт байдлаас үүсэх хор хохирлыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

Аюулгүй байдал судлал буюу “секьюритологи” секуритэ – аюулгүй байдал гэсэн латин үг, логос – үг, сургаал гэсэн грек үгний нийлбэр буюу орчуулбал “аюулгүй байдлын шинжлэх ухаан” гэсэн агуулгыг илэрхийлнэ. Үүний зэрэгцээ “секьюрити” (*англ. security*) гэсэн үг аюулгүй байдлын агуулга бүхий хамгаалалт, бэхлэлт, найдвартай чанар, хамгаалах, нууцлалт, хангалт, бүрэн бүтэн байдал, хадгалах, найдвар, аюулгүй байдлын байгууллага, сөрөг тагнуул зэрэг олон утгыг илэрхийлдэг байна. Аюулгүй байдлын мөн чанарын талаарх ойлголтыг дараах байдлаар ангилан авч үзэж болох юм. Үүнд:

Хүснэгт 1. Аюулгүй байдлын мөн чанарын талаарх ойлголт

Аюулгүй байдал, түүний мөн чанарын	Аюул заналд өртөгч объект бүрэн хэмжээгээр хохирол хүлээж болох байдлын эсрэг тал
	Гадаад талаас явуулж буй тодорхой зорилго, чиглэл бүхий устгаж үгүй хийх үйл ажиллагааны нөхцөлд өөрийн агуулга, үндсэн шинж чанарыг хадгалах чадвар
	Системийн категори бөгөөд энэ нь найдвартай оршин тогтнох, өөрөө зохицуулах, нэгдмэл бүхэллэг байдлын зарчим дээр буй болсон систем-тогтолцооны шинж чанар
	Хувь хүн, нийгэм, улс гүрний амьдрал үйл ажиллагааны шийдвэрлэх (баталгаа) нөхцөл бөгөөд тэдгээрт өөрсдийн материаллаг болон оюун санаа, бусад үнэт зүйлийг хамгаалах, өсгөн нэмэгдүүлэх боломж олгодог
	Сонгодог утгаараа материаллаг болон оюун санааны ертөнцөд аюул, занал байхгүйн илэрхийлэл
	Аюулын бодит илэрхийлэл болох занал, заналхийлэлээс хамгаалах, түүний эсрэг арга хэмжээний нийлбэр цогц

Үүнээс үзэхэд аюулгүй байдал нэг талаас занал, заналхийлэл, нөгөө талаас түүнтэй явуулах тэмцэл нь аюулгүй байдлын мөн чанарыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдал нь хамгийн ерөнхий

утгаараа “аюул заналхийлэлгүй орчин, аюулаас сэргийлэх хамгаалалт” юм.

Аюулгүй байдлыг хангах дараах элементээс бүрдэнэ.

Зураг 1. Аюулгүй байдлыг хангах элемент



Аюулгүй байдлын тогтолцоо систем дараах төрлөөс бүрдэж байна¹.

¹ Г.С.Вечканов. Эдийн засгийн аюулгүй байдал. – Уб., 2011. 17 дах тал.

Хүснэгт 2. Аюулгүй байдлын тогтолцоо

Аюулгүй байдлын төрөл	Хамрах хүрээ, чиглэл
Геополитикийн аюулгүй байдал	Геополитикийн буюу тухайн улс орны оршин буй газар нутгийн байршил зүйн онцлогоос үүдэлтэй төрийн улс төрийн бодлогод чиглэнэ
Нийгмийн аюулгүй байдал	Тухайн улс орны нийгмийн тогтолцоо, түүнд түшиглэнэ
Эдийн засгийн аюулгүй байдал	Улс, орны эдийн засгийн тогтвортой байдал, бусдаас хараат бус байх нөхцөл боломжийг хангахад чиглэнэ
Мэдээлэл, харилцаа холбооны аюулгүй байдал	Улсын нууц, харилцаа холбооны халдашгүй байдлыг хангахад чиглэнэ

Байгаль, газар зүй, экологийн аюулгүй байдал	Газар нутгын бүрэн бүтэн байдал, байгалийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэнэ
Техник, технологи, техникжилтийн аюулгүй байдал	Шинжлэх ухаан, технологийн дэвшил, хөгжилд тулгуурлан түүнийг ашиглахад чиглэнэ

Дотоод аюулгүй байдал. Улс үндэсний аюулгүй байдлыг хангах тулгуур асуудалд дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой. Хүн ам цөөн, газар нутаг уудам, байгалийн нөөц арвин зэргээс бусад улс орнуудын сонирхол татсан манай улсын хувьд дотоод аюулгүй байдлын асуудлаа онцгойлон анхаарахыг дэлхийд өрнөж буй үйл явц улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт, сорилт бэрхшээл бэлхнээ харуулж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах олон улсын практикт жижиг, дунд улсын үндэсний аюулгүй байдлын тэргүүн зэрэгт дотоод аюулгүй байдлын асуудал тавигддаг. Тодруулбал, гадны хүчнээс жижиг, буурай улсуудад чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ тухайн улсын дотоодод, тэр дундаа нийгмийн сэтгэлзүйд нөлөөлж тогтворгүй байдал бий болгон түүнийг


шийдвэрлэхдээ өөрсдийн ашиг сонирхлыг суулгадаг технологи хуучраагүй, харин ч шинэ агуулга, хэлбэрээр баяжиж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1.-д зааснаар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ ¹”. Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтдаг. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь төр, ард түмний онцгой анхаарал хамгаалалтад байна. Үндэсний

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж: <https://www.legalinfo.mn>

аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тодорхойлсон. Эндээс дүгнэхэд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Дотоод аюулгүй байдал”-ын хэсгийг боловсруулахдаа Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, хууль ёс, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, төрийн залгамж чанар, төрийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, түүний үндэс болох агуулгад тулгуурласан байна. Монгол Улсын дотоод аюулгүй байдал дараах тулгуур асуудлаас бүрдэнэ.

Зураг 2. Дотоод аюулгүй байдлын тулгуур



Үэг. Улс орны аюулгүй байдал. Улс гүрэн бүр өөрийн ашиг сонирхол, газар нутгын бүрэн бүтэн байдал, хүн амыг гадны болон дотоод аюул заналаас хамгаалах үүрэгтэй. Үүнд тодорхой аюул бүхий үйл явцын өрнөл улс орны болон түүний

улс төр, эдийн засгийн бие даасан байдлыг алдагдуулах хэмжээний занал, заналхийлэл бий болгох магадлал хамаарна.

Аливаа улс орны “Үндэсний аюулгүй байдал” гэдгийг өмнө нь улс төр, цэрэг дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагын үйл ажиллагааг хангах үүрэг хэмээн үзэж байсан цаг үе өнгөрч аюулгүй байдлын цар хүрээ, хангах арга замд өргөн цогц хэлбэрээр хандаж, зөвхөн төрийн үүрэг бус нийгэм, иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах, асуудлыг шийдвэрлэхэд иргэд хамтрах, хяналт тавих боломжийг олгох нь чухал гэж үзэх болсон. Монгол Улсын хувьд тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах нь төрийн үндсэн тулгуур чиг үүрэг байдаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, бүтээн байгуулах чиг хандлагатай байна. Монгол Улс нь эдийн засаг, соёл шинжлэх ухаан технологи, боловсрол зэрэг салбарт олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай байхыг чухалчилна гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал¹-д заажээ.

Улс орны үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйл нь олон улсын аюулгүй байдлаас голлон хамаардаг ба энэ ч утгаараа Монгол Улсын үндэсний аюулгүй

¹Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж холбоос: <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>

байдал нь олон улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд түүнээс шууд хамаарна.

Үндэсний аюулгүй байдлыг нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана. Тэгвэл үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр үйл явцын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь авах явдал юм.

Бүх нийтэд уламжлал болон тогтсон “улсын аюулгүй байдал” хэмээх ойлголттой зэрэгцэн “бие хүний аюулгүй байдал”, “үндэсний аюулгүй байдал”, “үндэсний ашиг сонирхол”, “аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйл” зэрэг нэр томъёо, ойлголт улам бүр хэрэглэгдэх болсон байна. Учир нь сүүлийн жилүүдэд аюулгүй байдлыг хангах талаар гарсан судалгааны материалыг үзэхэд энэхүү категорийн талаарх ойлголт ихээхэн өргөжиж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, урьд нь аюулгүй байдлыг ихэвчлэн улсын аюулгүй байдалтай холбон үздэг байсан бол 1980-аад оноос “нийгмийн аюулгүй байдал”-тай, харин өдгөө гол төлөв хувь хүний, нийгмийн, төр, улсын аюулгүй байдалтай холбон гурамсан нэгдлийн холбоон дотор авч үздэг болсон байна.

Монгол Улс 1990-ээд оноос эхлэн хуучин төлөвлөгөөт эдийн засгийн нийгмээс, зах зээлийн ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, 1992 онд шинэ Үндсэн хуулиа¹, 1994 онд Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлалаа², 2001 онд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиа³ тус тус батлан гаргасан байна.

Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хуулийг шинэчлэн баталсан явдал нь Монгол оронд хүний эрхийг ойлгох ойлголтыг эрс өөрчилж, бие хүн ба иргэний эрх, эрх чөлөөг жинхэнэ сонгодог утгаар нь ойлгож хэрэгжүүлэх боломжийг бий болгосон. Монгол Улсын Үндсэн хуулийн заалтаас харахад төрөөс олон нийтийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг дараах байдлаар хуульчлан тодорхойлж өгсөн байна. Үүнд:

➤ Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг: Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн;

➤ Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг: Монгол Улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ... хамгаалуулах эрхтэй;

➤ Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг: Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-аас баталсан. Цахим эх сурвалж, холбооц:<http://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>

² Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж, холбооц: <http://www.legalinfo.mn/law/details/6163>

³ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан. Цахим эх сурвалж. <http://www.legalinfo.mn/law/details/18>

зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна;

➤ Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт: Хүний эрх, эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Мөн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан нь эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчим, олон улсын гэрээ болох хууль зүйн үндэслэлийг тогтоосон чухал алхам бөгөөд улсын болон иргэнийхээ аюулгүй байдлаа хангах асуудлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хамгаалах үндсийг бүрдүүлж байна. Монгол Улс өнөөдрийн байдлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1946 онд баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” болон 1937 онд баталсан “Терроризмаас урьдчилан сэргийлэх, тийм үйлдлийг цээрлүүлэн шийтгэх тухай” Женевийн конвенци, 1973 онд баталсан “Олон улсын хамгаалалтыг хүлээх хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг урьдчилан сэргийлэх хийгээд шүүн цээрлүүлэх конвенци” (*Монгол Улс 1974 онд соёрхон баталсан*), 1979 онд баталсан “Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенци” (*Монгол Улс 1986 онд соёрхон баталсан*), 1998 онд баталсан “Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенци” (*Монгол Улс 2000 онд соёрхон баталсан*) зэрэг аюулгүй

байдлаа хангах, терроризмоос урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын 13 гэрээ, конвенцид нэгдэн оржээ.

Шинэ Үндсэн хууль батлагдсаны дараагаас эхлэн дэлхийн геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан улс орны аюулгүй байдлыг хангах шинэ үзэл баримтлалыг боловсруулах оролдлого улам эрчимжиж, Үндсэн хуулийн үзэл санаа, улс төрийн шинэ сэтгэлгээг эш үндэс болгон иргэн төвтэй нийгэм буюу “бие хүний аюулгүй байдлыг хангах” асуудлыг шинэ үзэл баримтлалын гол үндэс болгон сонгож авсан байна.

Зөвхөн бие хүний аюулгүй байдал нийгмийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тодорхойлж чадах бөгөөд дараагийн тэргүүлэх чиглэлд иргэний амь нас, хувийн өмч, эрх, эрх чөлөөг хамгаалах, улмаар эдгээрээр дамжуулан улс орон, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг дэвшүүлсэн байна.

1994 онд Монгол Улсын Их Хурал Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлалыг батлан төрийн бүх салбарын бодлого, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, олон түмний санаа бодлыг энэ чигт төвлөрүүлэхэд ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд 2001 онд баталсан Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зөвхөн төр болон түүний институтуудын аюулгүй байдал төдийгүй нийгэм, бие хүний аюулгүй байдлыг хангах тухай асуудлыг дэвшүүлэн тавьсан байна. Энэ нь эцсийн дүндээ нийтийн аюулгүй

байдлыг хангах зорилгыг дэвшүүлсэн байна¹.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 онд шинэчлэгдсэн ба шинэ үзэл баримтлалыг “Шинэ үзэл баримтлал нь нэг талаас үндэсний эрх ашгаа хамгаалах, эх оронч үндэсний үзлийг дээдлэх үзэл санаанд суурилснаараа уламжлалаа бататгасан, нөгөө талаас энэ хүрээнд иргэний оролцоог чухалчилж, хүний аюулгүй байдал, хүний эрх, хүний хөгжлийг тэтгэсэн бодлого явуулахаар тодорхойлсноороо шинэчлэлийг дэмжсэн агуулгатай болсон. Баримт бичиг бүхэлдээ иргэний эрх, иргэдийн оролцоог чухалчилж, анх удаа төрийн бодлогын үндэс болсон баримт бичигт “Хүний аюулгүй байдал”-ын асуудлыг тодорхойлж, өндөр түвшинд тавьснаараа нэн онцлог болсон” гэж дүгнэсэн байна.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.1. дэх хэсэгт: Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ”, 1.1.5. дахь хэсэгт: “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна”, 3.3. дахь хэсэгт: “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгуулалыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт

хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” хэмээн тусгасан байна.

Энэ бүхнээс шинээр баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Монгол Улсын тусгаар тогтнол, нийгэм, хувь хүний аюулгүй байдлыг цогц байдлаар хангахыг тодорхойлсон тулгуур баримт бичиг мөн гэж дүгнэж болох юм.

Хоёр. Тодорхой салбарын буюу байгууллагын аюулгүй байдал

Менежментийн шинжлэх ухаанд байгууллага гэдэг нь өмнөө тавьсан тодорхой зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартай зохицуулж байгаа бүлэг хүмүүс бөгөөд гадаад орчны нөлөөллөөс хамаардаг нээлттэй систем гэж тодорхойлсон байдаг. *Товчоор хэлбэл, байгууллага* гэдэг нь өмнөө тавьсан тодорхой зорилгод хүрэхийн төлөө үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулж байгаа бүлэг хүмүүсийн нэгдэл юм³. Байгууллагын аюулгүй байдал нь товчоор шинжлэх ухаан техник, технологи, хүний нөөцийн чадавхи, гадаад нөхцөл байдлын тааламжгүй нөлөөлөл зэрэг сөрөг үзэгдэл, үйл явдлаас аль хэр зохистой хамгаалагдсан эсэх тухай ойлголт юм. Байгууллагын аюулгүй байдлын гол зорилго:

➤ Ямар нэгэн нөхцөл байдлыг үл харгалзан үйл ажиллагаа дээд зэргийн тогтвортой үргэлжлэх боломжийг бүрдүүлэх;

➤ Үйл ажиллагааны бие даасан байдал, чадавхи, гадаад,

¹ Ж.Бор, В.Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. – Уб., 2012.

² М.Батчимэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: шинэ үзэл баримтлал-шинэ

бодлого. Стратеги судлал. – Уб., 2011. №53. 3 дугаар тал.

³ Б.Одбаатар. Байгууллагын удирдлага: онол, арга зүй. – Уб., 2016. 6 дахь тал.

дотоод оршин байх нөхцөлөө найдвартай хангах, зах зээлийн чадавхиа хадгалах

Хүн төрөлхтөн үүсч бий болсон цаг үеэс аюулгүй байдлаа хангах зайлшгүй шаардлага тулгарч түүнийг хэрэгжүүлэх арга замыг бий болгон улам боловсронгуй болгон тэмцсээр өнөөдрийг хүрсэн. Өнөө цагийн шинжлэх ухаан, техник технологи, эдийн засаг, нийгэм, соёлын хурдацтай хөгжил, даяаршилын нөлөөгөөр дан ганц хүний аюулгүй байдал бус улс орон, бүс нутаг, дэлхий нийтийн хэмжээнд улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээнд олон салбар бүхий аюулгүй байдлын талаар авч үзэх болсон бөгөөд үүний нэг хэлбэр нь байгууллагын аюулгүй байдал юм.

Эндээс дүгнэхэд байгууллагад нөлөөлдөг орчны асуудал аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлдэг нь харагдаж байна.

Дээрх хүчин зүйлсийн сөрөг, таагүй үзэгдэл нь байгууллагын оршин тогтнох, хөгжих, амжилт гаргах үйл явцад саад учруулж байдаг бөгөөд тэдгээрийг урьдчилан харан, сэргийлэх, эрсдэл багатайгаар давж гарах, цаашид дахин гаргахгүй байх талаар удирдлагын зүгээс зохион байгуулалттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гардаг.

Аливаа байгууллага улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан технологийн хөгжил, хүн ам зүй, байгаль экологи зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээний шууд болон шууд бус нөлөөлөл дор оршин тогтнож байдаг.

Эдгээр нөлөөллийн эерэг болон сөрөг талыг хэрхэн шийдвэрлэснээр тухайн байгууллага үүргээ амжилттай биелүүлж нэр хүнд нь өснө.

Байгууллагад нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг нөлөөллөөр нь гадаад дотоод, үүсэх үр дагавраар нь шууд ба шууд бус хүчин зүйл гэж ангилж болно. Өөрөөр хэлбэр улс орны төрийн байгууламж, эдийн засгийн байдал, соёл боловсролын түвшин, байгаль экологи, гэмт хэргийн өсөлт, бууралт болон дээд шатны байгууллагын удирдлага зохион байгуулалт, харилцагч байгууллага зэрэг нь гадаад хүчин зүйлс болно.

Тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, салбар нэгжийн харилцан ажиллагаа, уялдаа холбоо, удирдлагын арга барил, хамт олны боловсрол, эрүүл мэнд, амьдралын түвшин, мэргэжлийн ур чадвар, тогтоосон дэг журам, мэдээлэл, материаллаг үнэт зүйлсийг хэрхэн хуваарилан ашиглаж байгаа, технологийн горимыг нарийн чанд мөрдөж буй эсэх, сахилга бат зэрэг нь дотоод хүчин зүйлс болдог байна¹. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь байгууллагын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэж үздэг байна.

➤ Удирдах албан тушаалтны удирдлагын арга барил, мэдлэг, чадварыг тасралтгүй хөгжүүлэх;

➤ Төр, засгийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг зөв таниулж ойлгуулах;

¹ Ц.Цэрэндорж. Бидний менежмент. – Уб., 2008.

➤ Хууль, эрх зүй, удирдлагын баримт бичгийг сурталчлах, таниулах;

➤ Мэдээ, мэдээлэлд ямар нэг хязгаар тавихгүйгээр ач холбогдол өгч цуглуулах, судлаж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааны хэтийг төлөвлөх;

➤ Хүний нөөцийн менежментийг оновчтой зохион байгуулах (*хүнээ судлах, сонгон шалгаруулах, сургах, давтан сургах, албан тушаалд томилох*);

➤ Байгууллагыг эдийн засаг, санхүүгийн хувьд бэхжүүлэх;

➤ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангахад хөрөнгө зарцуулах;

➤ Техник технологийн дэвшлийг ашиглах;

➤ Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах;

➤ Хамт олны идэвхи санаачлага;

➤ Хяналт шалгалтын үр ашигтай тогтолцоог нэвтрүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлэх;

➤ Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн сахилгыг чанд мөрдүүлж, хариуцлагын шат дараалсан тогтолцоог бий болгох;

➤ Байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх;

➤ Байгалийн гамшиг, осол урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Энэ бүхнээс дүгнэхэд аливаа байгууллагын оршин тогтнох үндэс нь гадаад, дотоод орчиндоо дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаагаа орчны нөхцөлтэй уялдуулах, зөв бодлого хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь түүний урт удаан хугацаанд

оршин тогтнох чадвар, аюулгүй байдлыг бүрэн хангах үндэс болно.

Гурав. Хувь хүний аюулгүй байдал

Хүний аюулгүй байдлын үзэл санааг анх 1994 оны НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг “Хүний хөгжлийн тайлан”-д дэвшүүлэн тавьжээ. Үүгээр үндэсний аюулгүй байдлын эх сурвалж нь төр бус хүн юм гэж заасан онолын шинэ прадигм гарч энэ нь хүн төвтэй аюулгүй байдлын үзэл баримтлал нь улс үндэсний болоод бүс нутгийн, олон улсын тогтвортой байдлыг хамгаалах хадгалахад чухал үүрэгтэй гэж заасан.

Хүний аюулгүй байдал нь эдийн засаг, улс төр, нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, хүнс болон хувь хүний аюулгүй байдал гэсэн хүчин зүйлээр тодорхойлогдох бөгөөд хүн төрөлхтний хөгжин дэвших үндэс үзэл санааны нэгдлийн суурь болдог. Хувь хүн тус бүрийн баталгаа нь үндэсний аюулгүй байдлаар хангагдсан байх бөгөөд үндэсний аюулгүй байдал нь хувь хүн бүрт зориулж олон улсын аюулгүй байдлын хүрээнд эрхийг нь хамгаалах ёстой гэж үздэг байна. Үндэсний болоод олон улсын аюулгүй байдал нь хүний эрхийг дээдлэх, хүний эрх чөлөөг хувь хүн тус бүрт олгохгүйгээр амжилтанд хүрч чадахгүй гэсэн онолд суурилдаг байна. Хүний аюулгүй байдал болон хүний эрхийн асуудал нь нийтлэг талаасаа өөрсдийн хамаарах асуудлаас шалтгаалж хоорондоо зарим талаараа давхцдаг байна. Олон улсад хүний бүх эрх нь хүний аюулгүй байдлын гол цөм нь болгон авч үзэх ёстой гэж үзэж байна. Хүний аюулгүй байдал эрүүл хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой

хөгжил дэвшлийн эх сурвалж нь болсноор төр улсын аюулгүй байдал хангагдана. Нөгөө талаасаа төр нийгэм нь аюулгүй байж иргэнийхээ аюулгүй байдлыг хангана гэсэн хүн төвтэй аюулгүй байдлын үзэл, хүний эрүүл мэнд, байгаль орчин, хүнс аюулгүй байх зэрэг цогц шийдлийг бий болгох арга замыг шинээр цаг үетэйгээ нийцүүлэн шинэчилж байж Монгол Улсын аюулгүй байдал хангах ирээдүйн чиглэлийг тодорхойлно.

Монгол Улсын тухайд иргэдийн амьдралын аюулгүй байдал олон зүйл дээр хангагдахгүй байгаагаас хүн ёс бусаар амь үрэгдэх хэрэг, явдлын тоо өсөх хандлагатай байгаад дүгнэлт хийж, төр, засаг, хөдөлмөрийн хамт олноос иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар байнгын анхаарал, халамж тавих шаардлагатай байгаа юм. Судалгаагаар гэмт хэргийн улмаас 1551 хүн амиа алдаж, үүнээс 198 хүн бусдын гарт амь үрэгдэж, 450-500 хүн жил бүр авто тээврийн ослын улмаас амиа алдсан нь иргэдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах талаар дорвитой бодлого, үйл ажиллагаа үгүйлэгдэж байгаагийн дохио юм.

Аюул санамсаргүй үүсэх магадлал ховор. Ихэнх тохиолдолд аливаа аюулын өмнө ямар нэгэн үйл явдал, үзэгдэл юмс болж, аюулын тухай урьдаас мэдээлж, сэрэмжлүүлэх мэт байдаг нь бодит үнэн юм. Энэхүү урьдчилсан мэдээлэл, шинж төрхийг илрүүлэх, ойртож буй тухайн аюулын магадлалын зэрэглэлийн тусламжтайгаар дээрх мэдээлэл, шинж төрхийг задлан шинжилж, дүн шинжилгээ хийх, аюул нүүрлэх хугацаа, үзүүлж болох хор хөнөөл,

хүндрэл бэрхшээл зэргийг тодорхойлох нь аюул, заналыг шинжилж, дүгнэхийн үндсэн үүрэг юм.

Аюул заналын хэмжилт гэдэг нь тухайн аюул заналын чанарын шинж төлөвийг илүү тодорхой болгох, гүнзгийрүүлэх үүднээс тоон үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээ өгөхийн тулд түүний шинж төлөв, чанар байдлын тоон ач холбогдлыг тодорхойлох зорилгоор явуулж байгаа үйл ажиллагааны цогц юм. Дээрх жишээнээс аюул заналын хэмжилтийн аргачлалыг нээн харж болно. Тухайлбал, олон жилийн ажиглалт, хохиролын тоон үзүүлэлтийг тодорхойлж, тэдгээрийг жил жилээр нь, мөн бусад оронд болж өнгөрсөн тухайн төрлийн аюулын хохиролтой жиших, аюул заналын хэлбэршүүлсэн илэрхийллийн эзлэх хувийг тодорхойлох математик тооцоолол байж болно. Тоон болон чанарын үзүүлэлтийн харилцан үйлчлэл нь аюул бүхий үзэгдлийн тухай ойлголттой болоход ач холбогдолтой.

Эх сурвалжийн жагсаалт

-Монгол Улсын Үндсэн хууль.

Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. №1.

-Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос:

<http://www.legalinfo.mn/law/details/18>

-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос:<http://www.legalinfo.mn/law/details/564>

-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>

-Б.Одбаатар. Байгууллагын удирдлага: онол, арга зүй. – УБ., 2016.

-Г.С.Вечканов. Эдийн засгийн аюулгүй байдал. – Уб., 2011.

-Ж.Бор, В.Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. – Уб., 2012.

-М.Батчимэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: шинэ үзэл баримтлал-шинэ бодлого. Стратеги судлал. – Уб., 2011. №53.

-Н.Наранчимэг нар. Хүний

аюулгүй байдал. – Уб., 2009.

-С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. – Уб., 2007.

-Ц.Цэрэндорж. Бидний менежмент. – Уб., 2008.

-Ч.Улаанхүү. Аюулгүй байдал. – Уб., 2009.

-Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn